



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/324

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр /Хуучин Хаан банкны урд 111-р байрны өмнө/ байршилтай иргэн Сампил овогтой Цэрмаа /ЗЮ:53030101/-ын авто машины гаражийн зориулалттай 4809006454 нэгж талбар бүхий 18 м.кв /0,001 га/, 4809003559 нэгж талбар бүхий 18 м.кв /0,001 га/ газрыг иргэн Эрдэнэбат овогтой Уртнасан /ЗА:86061001/-д зориулалтаар нь шилжүүлж 25 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чэгнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/76, 2017 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн А/25 тоот захирамжуудыг мөн газар эзэмших 000712073, 000712066 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48090067